

## УГСААТАН СУДЛАЛЫН ОНОЛЫН ТОГТОЛЦОО

### И. Саруул

Монгол Улсын Их Сургууль, Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль, Угсаатан судлалын тэнхим

**Түлхүүр уг:** угсаатан, угсаажилт, үзэл баримтлал, биосфер,

Аливаа шинжлэх ухаанд эхлэн суралцахад эн тэргүүнд үндсэн ойлголтуудыг нь сайтар эзэмшсэн байх шаардлагатай. Угсаатан судлалын онол-сэтгэлгээний үндсэн асуудал бол *угсаатан /ethnos/, угсаажилт /ethnocity-/ын* ойлголтууд бөгөөд бусад бүх ойлголт, онол-сэтгэлгээ, судалгаа сургалтын бүхий л асуудлууд нь суурилж байдаг. Угсаатан, угсаажилт хоёр нэр томъёоны ойлголтууд нь дэлхийн *ард түмэн* гэсэн нэг үзэгдлийг өөр өөр байр сууринаас тайлбарлаж байдаг /1.т.23./.

Угсаатны онолыг боловсруулан хөгжүүлэхэд оросын эрдэмтэн С.М. Широкогоров онцгой зүйл хийж, уг онолыг бүтээх анхны суурь алхмууд гол төлөв түүний нэртэй холбоотой юм. С.М. Широкогоров угсаатны хэв шинжийг **Угсаатан бол нэгэн угсаа гаралтай, нэгэн хэлээр харилцдаг, нэгдмэл цогц ёс заншил, ахуй амьдралын хэвшилтэй, түүнийгээ уламжлалаараа дамжуулан сахин хадгалахдаа улам боловсруулан баяжуулж байдал бөгөөд эдгээр зэрэг шинжүүдээрээ угсаатны бусад нийтлэгүүдээс ялгарч байдал хүмүүсийн нийтлэг юм** (8.т.13.) гэж тодорхойлсон явдал шинжлэх ухаанд угсаатны нийтлэгийн ойлголтыг үндэслэсэн анхны тайлбар юм.

С.М. Широкогоровын бүтээл нь 1920-иод онд . угсаатан, угсаажилтын асуудлыг шинжлэх ухааны үүднээс ухааран ойлгох түүхэн анхдагч тайлбар байв. Харамсалтай нь түүнийг орос орноос дүрвэсний улмаас үзэл баримтлал нь зөвлөлт засгийн цагт зөвшөөрөн хүлээгдээгүй, тэр ч байтугай орчин үед түүний боловсруулсан угсаатны онол-сэтгэлгээ нь бүрэн эхээрээ нийтлэгдээгүй энд тэнд хэсэг бусагаар өнөө хүрчээ (2.т.101.).

Дэлхий дахины бүх оршин суугчид түүхэнд олон төрөл хэлбэрийн нийтлэгүүдийг бүрдүүлж байснаас хүн төрлөхтний соёлд эзлэх байр суурь, ач холбогдол, гүйцэтгэх үүрэг болон түүхэнд хамгийн урт удаан хугацаанд бат бэх суурьтайгаар оршин тогтнож байгаа нийтлэг бол угсаатны нийтлэг буюу этнос болно (2.т.82.). Нийтлэг гэсэн нь нэгдмэл чанар, адил байх агуулгатай бөгөөд угсаатны нийтлэг ойлголтонд ард түмэн түүх, ахуй орчин, соёл, ухамсраар нэгдмэл чанарын ойлголт болно. Этнос нэр томъёог монгол хэлэнд угсаатан гэж тодорхойлоходоо ард түмний угсаа гарал, холбоо хамаарал, соёлын уламжлал зэргийг оноож буй.

Угсаатны нийтлэгийн онол-сэтгэлгээг дэлхийн олон орны эрдэмтэд боловсруулан хөгжүүлж ирсэн хэдий ч ОХУ-ын эрдэмтдийн сэтгэлгээ нь цэгцэрсэнээрээ ялгарч байна. Эрнөдийн орнуудын бүтээлд хараахан ийм цэгцэлсэн онол-сэтгэлгээ байхгүй, олон зам чиглэлээр салбарлажээ. Манай угсаатан судлаачдаас угсаатны онолын асуудлаар сэдэвлэн ажилласан бүтээл хараахан үгүй бөгөөд их дээд сургуульд хичээл заах төдийгөөр хягаарлажээ. Угсаатан судлалын шинжлэх ухаанд судалгааныхаа арга барил, онолын чиглэлээсээ хамаарч угсаатны хэд хэдэн үзэл баримтлалууд дэвшигдээд байна. Энэ нь: - **Дуалист үзэл баримтлал;** - **Пассионарийн үзэл баримтлал;** - **Мэдээллийн үзэл баримтлал,** - **Системийн статистик буюу бүтэц бүрэлдэхүүний үзэл баримтлал** болно.

- **Дуалист үзэл баримтлал.** Энэхүү үзэл баримтлалыг ОХУ-ын этнологи, антропологийн хүрээлэнгийн Ю.В. Бромлей тэргүүтэй хэсэг эрдэмтэд дэвшүүлжээ. Хүн төрлөхтөн биологи махбодын хувьд нэгдмэл, нийгмийн нэгдмэл хуулийн дагуу хөгжихийн хамт түүхэн ёсоор бүрэлдэн төлөвшөн янз бүрийн төрлийн нийтлэгт салбарлаж байдаг. Тэдгээрээс угсаатны нийтлэг нь хүмүүсийн нэгдэн оршин

амьдрах нэгэн онцлог хэлбэр бөгөөд ямар ч нийгэм-эдийн засгийн байгуулалтын нөхцөлд маш тогтвортой тогтнож байдгаараа бусад нийтлэгүүдээс ялгарна. Тиймээс нийгмийн хөгжилд чухал байр суурь эзлэх бодит үзэгдэл байна.

Угсаатны нийтлэг нь ард түмний бүтээсэн соёл, ухамсын нэгдэлд суурилсан нийгмийн онцлог хэсэг хүмүүсийн нийтлэг бөгөөд хоёр төрлийн шинж чанар түүнд үйлчилж байдаг байна. Тэр нь: 1. Угсаатны төрөлх чанар (үндэсний хэл, ахуйн соёл, зан үйл, эдгээр бүхнийг нэрэндээ шингэсэн байдаг); 2. Угсаатны тогтнолтонд нөлөөлөх хөндлөнгийн шинжүүд (байгаль, газар зүй, газар шороо, нийгэм-эдийн засаг, төр эрх зүйн хүчин зүйлүүд) байна. Эл хоёр шинж чанараараа угсаатан нь **этникос** ба **угсаатны нийгмийн тогтолцоо** (этносоциал организм) гэсэн хэлбэрүүдтэй тул дуалист буюу хос (хам) гэж нэрлэгджээ.

Этникосыг ... *тодорхой нутаг дэвсгэрт түүхэн ёсоор бүрэлдсэн соёлын нийтлэг, харьцангуй тогтвортой нэгдэлтэйгээ ба төстэй өөр бусад бүхий л тогтолцоонуудаас ялгаатайгаа ухамсарлаж, өөрийн нэрэнд бэхжүүлсэн ухамсартай хүмүүсийн нийлбэр цогц мөн* (12; 7.т.182.) гэж тодорхойлж, угсаатны нийтлэгийн явцуу ойлголт хэмээн тайлбарлажээ. Энэ бол угсаатны нийтлэгийн төрөлхийн шинж чанар бөгөөд мэдээллийн диахрон холбоо буюу угсаатны залгамж чанарын тогтолцоог тодорхойлдог байна.

Харин угсаатны нийгмийн тогтолцооны өргөн утгын ойлголт нь угсаатны нийтлэгийн гишүүдийн дур зоргоос үл хамаарахын дээр түүний залгамж бүрэлдэх ба төлөвшин тогтоход нөлөөлөх хүчин зүйлс хамаарна. Мэдээллийн синхрон холбоо буюу угсаатны үндсэн шинжүүдэд улс төр, эдийн засаг, нийгэм, соёл зэрэг үйлчиллийг нутаг дэвсгэрийн байршилтаар нь авч үздэг. Угсаатны нийгмийн тогтолцооны хүрээнд угсаатны цөм бүрэлдэн төлөвшиж, түүнийг хөгжлийг хангаж байдаг байна.

Явцуу ба өргөн утгын түгээмэл жишээ бол дэлхийд тархан амьдарч буй украинчууд этникос, тодорхой улсын нутаг дэвсгэрт оршин буй украинчууд бол угсаатны тогтолцоо байна. Угсаатны нийтлэгийн төрөлх шинж тэмдэг, түүнд хөндлөнгөөс нөлөөлөх чанарууд нь хосолж, эсвэл синхрон ба диахрон холбоо нь угсаатны нийтлэгийн эв нэгдлийг ханганд сахиулдаг байна.

**Пассионарийн үзэл баримтлал.** Угсаатны үзэгдлийг тайлах пассионарийн үзэл баримтлалыг оросын эрдэмтэн Л.Н. Гумилёв дэвшүүлсэн маш өвөрмөц билээ. Академич В.И. Вернадскийн биосфериин тухай сургаалаас санаа авч гаргасан. Хүмүүсийн амьдралд од гариг, эрхсийн хөдөлгөөний гүйцэтгэх үүргийн тухай үзэл, ухаан дорно дахинд нилээд дээр цагт бүрэлдсэн түүхтэй. Хожим өрнөдөд газар дэлхий дээрх амьдралд од гараг, эрхсийн хөдөлгөөний учир холбогдоор оросын эрдэмтэн Л.Н. Гумилёв (10), А.Л. Чижевский (11) нарын үзэл баримтлал олны анхаарлыг ихэд татаж дэлгэрчээ. Түүний үндсэн санаа, агуулга дараах байдалд оршино.

Юуны өмнө угсаатан нь нийгмийн бүрэлдэхүүн хэсэг боловч биологийн амьд махбод /организм/-ын хувьд эх дэлхийн биосфер /шим ертөнц/-ийн бүтээл, түүнтэй салшгүй хүйн холбоотой байна. Биосфер, ноосфер /юун ертөнц/-ийн онолыг үндэслэгч В.И. Вернадскийн тодорхойлсноор **биосфер бол манай гаригийн амьд махбодын тогтолцоо ба түүний хувьсган бүтээсэн дэлхий бөмбөрцгийн орчин мөн** гэжээ. Энд мөн агаар мандал хамаарч буй. Дэлхийн бөмбөрцөг, хүн хоёр нь олон сая миллиард он жил тасралтгүй өрнөсөн эх дэлхийн биосфериин тасралтгүй хувьсал хөгжлийн зүй тогтолт үр дүн, гайхамшигт бүтээл нь билээ. Иймд дэлхий бөмбөрцгийн орчинд хамаарах агаар мандал, эх дэлхийн бөмбөрцөг, хүн гурав биосферт харилцан бие биенээ нөхцөлдүүлэн амьдруулж, салшгүй холбоогоороо биосфериин оршин үйлчлэх тогтолцооны зүй тогтолтой байна.

Харин хүн биосфериин оршин үйлчлэлд хэрхэн татагдан оролцож байдаг асуудалд Л.Н. Гумилёв угсаатан буюу угсаатны оршин тогтох орчны

тогтолцоогоор нэвтэрч, харилцан үйлчилж байдаг байна. Тэгснээр этносфера, антропосфер тогтолцоо бүрэлдэн тогтдог байна.

Биосфер болон угсаатны орчны тогтолцоонд /этносфер/ газар буюу эх дэлхий маань үндсэн үүрэг гүйцэтгэдэг. Биосфериин өөрийгөө зохицуулах тогтолцоо гайхамшигтай үзэгдэл бөгөөд эх дэлхийн орчин тойрныг тасралтгүй хувьсан бурдуулсээр байгаа билээ. Сансрыйн хөгжлийн гараанд эх дэлхий маань анх хатуу хүйтэн чулуун бөмбөлөг хэлбэртэй тогтох, түүний гадаргуу нь хүчилтөрөгчийн нимгэн бүрхэвч, агаар мандалын хийгээр хүрээлэгдэж байжээ. Гэтэл өнөөгийн дэлхийн дүр төрх, оршин байгаа байдал нь аянхныхаа бурдлээс эрс ялгарах бөгөөд биосфериин бүхэл бүтэн тогтолцоонд оршин танигдашгүй болжээ. Тиймд В.И. Вернадский дэлхийн **биосфер төлөөвших явдал нь газар зүйн /геологийн/ агуу их хүч юм. Өнөөгийн галт уулын дэлбэрэлт, тивүүдийн байршилын өөрчлөлт зэрэгтэй харьцуулахад өчүүхэн үзэгдэл болно** гэж тэмдэглэжээ.

Л.Н.Гумилёв угсаатан, газар хоёрын шүтэлцээний асуудлыг нарийвчлан тайлбарласан байдаг. Хүн төрлөхтний угсаатны нийтлэгүүд нь дэлхий бөмбөрцгийн гадаргуу дээр газар зүйн байршилаараа энд тэнд оршин амьдарч буй. Тэдгээр газрын гадаргуугийн тогтолцоо /ландшафт/ угсаатанд шууд нөлөөлж, амьдралын эх ундраа болдог. Тиймээс Л.Н. Гумилёв газрын гадаргуу /ландшафт/ нь угсаатан оршин тогтонох үндсэн нөхцөл нь гэж үзжээ.

Тэхдээ хүн ухамсырын /юуны чадавхтай/ зохион байгуулалттай, хүсэл зорилго бүхий оршихдоо амьдран буй орчноо хувьсах чадвартай. Үүгээрээ байгалийн бусад бүх үзэгдлээс ялгарах гайхамшигтай ололт. Ургамал, амьтны ертенцэд ийм чадвар заяагаагүйн дээр байгалийн жамаар оршино. Хүн ямагт биосфертэй зохицолдсон сайн сайхныг бүтээх тэмүүлэлээр идэвхтэй үйл ажиллагаа өрнүүлдэг. Харамсалтай нь цөөнгүй тохиолдолд биосфериин өөрийгөө зохицуулах тогтолцоог зөрчиж, улмаар сайн сайхны хүлээлт нь экологийн сүйрэлд хүргэж болзошгүй. Үүний баталгаа нь эртний Месопотами, Египетийн соёлоос хоцорсон говь цөлүүд гэрчилнэ. Иймд Л.Н. Гумилёв газрын гадаргуу /ландшафт/ нь угсаатантай хүйн холбоотой хийгээд экологийн сүйрэл нь угсаатныг мөхөөх нэгэн томоохон хүчин зүйл, ноцтой шалтгаан нь гэж баримталжээ. Хүн төрлөхтний соёл иргэншил бүхэлдээ ч, тухайлан авсан аль нэгэн улс үндэстний хувьд ч газар зүйн орчны шалтгаанаар оршин тогтоно, мөн тэрхүү шалтгааны улмаас мөхөн дорийтох, устаж үгүй болох зүй тогтолтой гэж үндэслэлээ тавьжээ (9.т.101.).

Гагцхүү биосфериин энэхүү агуу их хувьсал хөгжилтэнд, тодруулбал эх дэлхий ба угсаатны оршин тогтнолт нь байгалийн асар их эрчим хүчиний зарцуулалтыг шаарддаг байна. Байгальд эрчим хүчээ хадгалах хуулийг В.И. Вернадский нээж, **биогеохимиийн** эрчим гэж тодорхойлжээ. Эрчимиийн эх сурвалж нь нарны цацрагийн эрчим хүч, сансрын эрчим хүч, дэлхийн гүн дэх цөмийн радио идэхт урвал /химийн зарим махбодын атомын цөм өөрөө задран цацраг гаргах/-ын эрчим байна. Эдгээрийн хүчин зүйлээр биосфериин амьд махбод үүсэн төлөөвшинэ. Иймд Л.Н. Гумилёв угсаатан оршиход эрчим зайлшгүй шаардана, аливаа үндэстэн угсаатнууд эдгээр эрчимиийг өөртөө шингээн авч, авсан үедээ сэргэн хүчирхэгжиж, цэцэглэн мандана, уг хүч дуусах дөхөөд ирэхлээр уруудан дорийтох, улмаар унаж мөхөхийн ирмэгт тулна (9.т.102.) гэж тайлбарлажээ.

Биосфер оршин тогтнож байхад хамгийн гол нь нарны эрчим хүч их чухал үүрэг гүйцэтгэж, биосфериийг бүхэлд нь тусган амьдруулж байдаг байна. Харин угсаатны оршин тогтнолтонд сансрын туяаны тусгал тун чухал үүрэг гүйцэтгэнэ гэж Л.Н. Гумилев үзжээ. Мянган жилд манай дэлхий нэг удаа онцлог төрлийн сансрын цацраг туяажилтанд автдаг байна. Эрчим хүчиний нэг эргэлт нь 1200-1500 жил үргэлжлэнэ, эхнийх нь дуусмагц дараагийнх нь тулхэлтээс ирнэ (9.т.104.).

Туяажилт нь хоромхон зуурын хугацаанд хүнд эрчимээ үзүүлж, хүн эрчимиийг шингээн авснаар мутаци бий болно. Тэгснээр онцгой үйл ажиллагааны идэвхтэй

эрчимт хүмүүс тодрон гарна. Эрчимт хүн гэж зохих хэмжээнээсээ эрчим хүч нь хэтэрч давсан гарамгай суут маягийн хүмүүс болно. Ийм хүмүүс адиl зан төлөв, араншин, ухамсартай, хамтдаа цугларч нэгдмэл зорилго тавьж биелүүлдэг байна. Тэд ард олон, улс орныхоо төлөө өөрсдийн амь амьдралыг эс хайрлан, үндэснийхээ бие даасан байдал, тусгаар тогтнол, хөгжил дэвшилд саад болоч бүхэнтэй хайр найргүй тэмцэл хийнэ. Энэ нь амьдрах тэрхүү эрчимт хүч нь ихэдсэнийх бөгөөд тэдгээр хүмүүс уг эрчимт хүч хэвийн байдалд орон ортол тэмцэл тулалдаанаа үргэлжлүүлнэ (9.т.103.). Тэд хүнд бэрх нөхцөлд аминч хүмүүсийн ноёрхлын эсрэг тэмцэж, гол төлөв амь нас амьдралаараа хохирох боловч өөрийн үзэл бодлыг түгээн тархааж, хойч үеийнхэндээ тэмцэх замыг нь нээж өгдөг (9.т.104.).

Л.Н. Гумилевын пассионари баримтлалд биосфер бүх үзэгдэл тохиолдлын бус, эмх цэгц системийн /цогц/ байдалтай оршин тогтоно. Дэлхий ертенц нь дотоод гадаад махбодуудын олон системийн иж бүрдэл юм. Угсаатан мөн энэ системд хамааралтайн дээр этносфериин тогтолцоогоор бие даасан бүхэл бүтэн системийг бүрдүүлдэг. Тэдгээр систем гэвэл: 1. **Нээлттэй** – хүрээлэн буй орчин тойронтойгоо байнга бодис, энергийн хүчний солилцоонд оршдог; 2. **Хаалттай** – Орчинтойгоо бодисын солилцоо хийдэггүй, зөвхөн энергийн солилцоо явуулна. Дэлхий сансрын бусад од гариг эрхсийн хувьд хаалттай систем, тодорхой цаг хугацаанд ямар нэгэн энергээр хангагдаж байдаг. Тэхлээр нэг л удаа эрчимиийн хүчийг хүртээд зарцуулж гүйцээдэг; 3. **Хатуу** – бүтцийн бүх махбодууд нь заавал бүрдэж байж хэвийн ажиллагаатай, аль нэг нь үгүй байвал нийт системийн ажиллагааг алдагдуулдаг байна; 4. **Дискрет** /тасралтгүй/ – Махбодын хоорондын хэлхээ холбоо нь төдий л бат бэх бус байна.

Л.Н.Гумилев угсаатныг *дискрет* маягийн *хаалттай* системээр тодорхойлсон. Сансырын туяажилтын пассионари түлхэцээр угсаатан эрчимиийн цэнэг хүртэж, түүнийгээ зарцуулж гүйцээхээр орчинтойгоо зохицох, эсвэл хэсэг хэсгээрээ задран тархдаг байна. Нэгдмэл зан төлөв төрхтэй, дотоод онцлог бүтэцтэй, “тэд – бид” гэсэн дихотомоор өөрсдийгөө бусдаас ялган салгаж байдаг байгалийн хүмүүсийн нийтлэг (угсаатан) нь биосферт чухам ингэж амьран оршидог байна.

Хүмүүс нэгдэж угсаатныг бүрдүүлэх явц нь Л.Н. Гумилевын саналаар **комплиментарностийн зарчмаар** өрнөнө. Тэр нь ухамсраас үл хамаарч хүмүүсийн харилцан таашаах (симпати – иерэг таашаал), эсвэл эс таашаах (антитапти – сөрөг таашаал) харилцаагаар тогтоно. Өөрөөр хэлбэл, иерэг таашаалын чанартай хүмүүс өөр хоорондоо ойртон нийлж угсаатны нийтлэгүүдийг бүрдүүлдэг байна.

Комплиментарностийн /таашаалын/ зарчим нь угсаатны дотоод хүрээнд ч үйлчилнэ. Тэр нь эх оронч үзэл (патриотизм), амьтныг гаршуулах, гэр бүл ураг төрлийн холбоо тогтоох зэрэг олон мэдрэмжүүдийг төлөвшүүлнэ. Иймд Л.Н. Гумилёв таашаалын зарчмыг нийгмийн үзэгдэл бус гэж үзжээ.

Хүний мэдрэмж байгалийн бодисын эрчимиийн солилцоотой шууд холбоотой. Учир нь биосфериин амьд бодисийн эрчим нь тодорхой физик чанартай байна. Бодгаль хүний хувьд бол био орны хувилбарууд байх ёстой, тэр нь биоорны нэгэн төрөл байна. Биоорон нь янз бүрийн давтамжтай хүчний шугамуудын хэлбэлзлээр тодорхойлогоно. Ингэхлээр угсаатан пассионарийн орны хэлбэлзлийн систем байдаг. Пассионари хэлбэлзлийн оронг эзэрг таашаалын чанартай хүмүүс бий болгоно. Хувь хүмүүсийн хэлбэлзлийн давтамж нь таарч зохирол гарна. Ингэхэд пассионари бус бодгалиудад нөлөөлөн нэгтгэгдэх замаар хамаарч хэмнэлийг өлдөг байна.

Угсаатны нийтлэгүүд өөр хоорондоо харилцаа холбоонд оршиход тэдний пассионари орны хэлбэлзлийн хэмнэл нь давхцдаг байна. Тэдний пассионари орны үечлэл нь тохирч давхцахаас шалтгаалж зохирол, эсвэл эс зохирол гарна.

Эхний тохиолдолд угсаатны нэгдэл, хоёрдох нэхцэлд аль нэгнийх нь, эсвэл аль алиных нь орны хэмнэл алдагдаж угсаатны харилцаа холбоо алдагдан доройтох, тохиромж муутай нэхцэлд тэрхүү хэлхээ холбоонд оролцож буй гишүүдийн мөхөлд хүргэж болзошгүй. Ингэснээр Л.Н. Гумилел этносын “тэд – бид” гэсэн үндсэн тодорхойлолтыг комплиментарностийн мэдрэмж гэж үзжээ.

Л.Н. Гумилев угсаатныг өөрийн өвөрмөц онцлогтой, тодорхой үеүүдэд амьдардагаараа “**биосоциал организм**” мөн гэж үзэж өөрийн үзэл баримтлалдаа угсаатны үүслийн асуудлыг өөрөөр хэлбэл, угсаа гарлын судалгаанд үлэмж анхаарал тавьсан юм. Угсаатны гарлыг үндсэндээ газар зүйн ба газар сансрын хүчин зүйлүүдээс шалтгаалсан үйл явц мөн, харин угсаатны төлөвшлийг сансрын эрчим хүч, газрын төрх байдлын онцлогуудын цогц үйлдлийн бүтээгдэхүүн мөн гэж авч үзсэн байна (6; 7.т.181.)

Ийнхүү Л.Н. Гумилёв эрчим хүчиний үзэл баримтлалаараа нийгмийн үзэгдлийг байгаль дэлхийгээс авах **биогеохимиийн** эрчим хүч, байгаль цаг агаар, түүнчлэн нийгмийн шинжтэй хүчин зүйлүүдийг харьцуулан тайлбарлах үндэслэлийг бий болгожээ.

**Мэдээлэлийн үзэл баримтлал.** Оросын этнологийн шинжлэх ухаанд орчин үеийн угсаажилтын асуудлыг тайлбарлах инструменталист (хэрэглээний) хандлагын баримтлалын жишээ бол Чебоксаров Н.Н., Арутюнов С.А. нарын этносын мэдээлэлийн үзэл баримтлал юм. Тэд нар бүх угсаатны нийтлэгүүд оршин тогтонох механизмыг ард түмний харилцаа холбооны үндсэн дээр бүрдэж байдаг мэдээлэлийн ойлголтоор тайлбарлахыг санал болгожээ. Мэдээлэл нь харицаа холбооны янз бүрийн хэлбэрээр байна. Хүмүүсийн ямар ч харилцаа холбоо нь мэдээлэл дамжуулалтаар арвин байдаг бөгөөд янз бүрийн суваг: хэлний харилцаа, үзүүлэх хэлбэр, дууриан харуулах зэргийн тусламжтайгаар дамжуулна. Мэдээлэл гэсэн ойлголтонд мөн соёлын уламжлал, түүний уран бүтээлийн өв орно.

Мэдээлэлийн загвар өнөөдрийн угсаажилтын асуудлыг тайлбарлахад маш эвтэйхэн байна. Угсаатныг зөвхөн эдийн засаг, улс төрийн зорилгодоо хүрэх хэрэгсэл гэж үзээд зогсохгүй, бас тодорхой сэтгэл зүйн тогтворт байдалд хүмүүсээс суурь хэрэгцээ шаардлагаа хангах арга юм. Орчин үеийн хүнд хэцүү амьдрал, нэр сүр алдагдах, хариуцах эзэнгүй байдал, үймээн сандрал, тогтвортой байдлын эсрэг хүн төрлөхтний өөрсдийгөө хамгаалан сахих хариу үйлдэл нь угсаатны чухал ололт болохыг судлаачид улам л хүлээж буй. Угсаатан нь нэгэн ёсондоо мэдээлэлийн шүүлтүүрийн үүрэг гүйцэтгэдэг байна. Амьдралын сэтгэл зүйн хэрэгцээ шаардлагаар мэдээлэлийн шүүлтүүрийн шаардлага гардаг байна. Энэхүү шаардлага нь хүн амьд биетийн нэгэн төрөл болохын хувьд одоо байгаа мэдээлэлийн нэхцлөөс тэс ондоо орчинд бүрэлдэн амьдарч байснаар тайлбарлагдаж байна.

Бүхий л түүхийн туршид хүн нийгэмд шаардлагатай мэдээлэлийг цөөн тоотой тодорхой бүрэлдэхүүнтэй бүлгүүдээс хүртэж байжээ. Тэд авсаархан тосгонд амьдарч, оршин суугчид нь бүгд бие биенээ танина. Бүлгийн тогтвортой байдал нь үеэс үед уламжлан гишүүдийн дунд ертөнцийг адил төсөөлөх, үнэлээмжийн нэгдмэл ойлголт, ижил зан төлөв, амьдралын утга учрын тухай ойлголт зонхилж байжээ. Үүний үр дүнд орчин үеийг бодвол хүнд хүрч байсан нийгмийн мэдээлэл нь харьцангуй нэгэн төрлийн, тодорхой хэмнэлтэй, дэс дараалалтай байж, түүнд үзүүлэх хариу үйлдэл нь нэгэн төрлийн байжээ.

Гэтэл орчин үеийн нийгэмд хүн нэгэн зэрэг өөр хоорондоо сулхан харицаа холбоотой бүлгүүдэд хамаарах болжээ. Бүлэг бүр нь хоорондоо тохирон зохицсон төдийгүй бас зерчилдсөн шаардлагуудыг нэгэн зэрэг хүний зан байдалд тавьдаг байна. Иймээс хүн бүрэлдэн тогтох явцад төлөвшсөн хариу үйлдлийн сэтгэл зүйн тогтолцоо нь шинэ мэдээлэлийн орчинтой тохирсгүй зөрчилдөж байна.

Сэтгэл судлаачдын тогтоосноор хүний мэдээлэлийн бололцоо нь хязгаармагдмал, хүнд хохирол учруулахгүйгээр хэмжээ хязгааргүй хөгжиж чадахгүй. Энэ байдлын хүчин зүйлийн үрээр түүний тогтвортой байдал руу тэмүүлэх нь зан төлөвийн чухал шалтаг болдог байна. Энд угсаатны үнэлэмжүүд нь өөрийнхөө тогтвортой байдлаараа удамшин үе дамжиж байдгаараа бусад хүчин зүйлүүдээс маргашгүй давуу талтай байна. Дундаж хүний мэдээлэлийн боломжуудын хоорондын зааг байгаа ба мэдээлэлийн нөхцлийн хүнд хэцүү байдал хичнээн их байна төдий чинээ угсаатны ухамсын сэтгэл хөдлөлийн тал буюу өөрийн ард түмэнд харьяалах, үндэсний хэлээ хэрэглэх, ёс суртахууны үнэлэмжүүд, уламжлалт хөдөлмөрийн дадлага туршлагыг сэргээх эрмэлзлэл давамгай хүчтэй байна.

Хүн ертөнцийг эмх замбраагүй төрх, бэлэгдэл (символ) ба ойлголтууд гэж хүлээн авдаггүй. Гадаад ертөнцөөс ирж байгаа мэдээлэлүүд нь бидний ухамсарт хатуу тогтсон ойлголт ба символуудын цэгц байдлын ертөнцөөр дамжин гардаг. Энэ ертөнцийг үзэх энэхүү схем нь зөвхөн түүнд урьдчилан тогтоогдсон мэдээлэлүүдийг боловсруулдаг байна. Харин өөрт нь зохицсон нэргүй, бидэнд түүний тухай төсөөлөл байхгүй бол түүнийг анхаардаггүй байна. Бусад бүх мэдээлэлийг ертөнцийг үзэх ерөнхий байдлаар бутцэлдэг байна: Өөрийн үзэл баримтлалын дагуу чухал биш гэснээ гээгдүүлж, чухал гэсэн дээрээ анхаарлаа төлөрүүлнэ. Ертөнцийг үзэх үзлийн үндсийг угсаатны үнэлэмжүүд бүрдүүлдэг. Иймээс мэдээлэлийн чухлыг угсаатны байр сууринлас үнэлэх явдал юм. Ийнхүү угсаажилт нь мэдээлэлийн шүүлтүүрийн үүргээр илэрдэг бөгөөд бодгал хүний мэдээлэлийн бололцоон дээр тулгуурласан нийгмийн хэм хэмжээний мэдээлэлийн тогтвортжуулагч байдаг.

**Системийн статистик буюу бүтэц бүрэлдэхүүний үзэл баримтлал.** Энэхүү үзэл бодлын ёсоор угсаатан түүхэн ёсоор бүрэлдэн тогтох хөгждэг, өөрийгөө нөхөн үйлдвэрлэх ба өөрийгөө зохицуулж байдаг нийгмийн хүндхэн систем юм. Систем нь дотроо олон хэсгээс (композици) бүрдсэн нарийн бүтэцтэй. Дээд зэргийн бүтцүүд олон компонентуудтайд тооцогддог. Компонентүүд нь дараах байж болно: 1. Угсаатны тархан суурьшалт, оршин суугчдын хэсэг болохын хувьд түүний нөхөн үйлдвэрлэл ба түүнд зохицсон хүн ам зүйн бүтэц, эдийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа ба түүний шинж чанар; 2. Нийгмийн харицаа ба байгууллагуудын систем; 3. Хэл ба түүний аялгууны үйл ажиллагааны янз бурийн хэлбэрүүд; 4. Ахуй буюу тогтсон зан араншигийн байдал, дэг журам – эдгээр нь зан заншил, нийэмийн зуршил, зан үйл зэргээр илэрч байдаг; 5. Өөрийн болон дэлхийн этносыг хүлээн мэдрэх онцлог талууд; 6. Эцэст нь угсаатны бодгалийн хувь харилцаа ба харилцан ажиллагаа зэрэг болно.

Бүтэц бүрэлдэхүүн нь нөхцөл байдлаас шалтгаалж өөрчлөгдж байдаг боловч бүрэлдэхүүнүүд нь хоорондын хэлхээ холбоогоо хадгалж байдаг. Угсаатны бүрэлдэхүүнийг онолын хувьд, мөн ажлын шаардлагын дагуу хичнээнээр ч угсаатны шинжүүдийг байрлуулж (цэгцэлж) болно. Эдгээр нь бодитоор орших угсаатны амьдралын бүхий л талыг тодорхойлж, шүүн шалгах шалгуур (индикатор) нь болно.

Энэхүү үзэл баримтлалыг зохиогчдын саналаар бол бүрэлдэхүүнээр тоочин бичих, угсаатныг тус бүрээр нь судлах нь системийн онол, вариацийн статистик аргуудыг хэрэглэх өргөн бололцоог олгодог байна. Тухайлбал, стандарт асуулга зохиох, аргуудыг сонгож хэрэглэх, цуглуванс мэдээгээ машинаар боловсруулах ба түүний задлан шинжилгээг математикийн мэдээлэлийн онолын үндсэн дээр хийх нь угсаатны бүтцийг загварчлах ба угсаатны үйл явцыг машин дээр загварчлах өргөн бололцоо олгодог байна.

x            x            x

Тэгэхлээр дээр дурдсан угсаатан судлалын үзэл баримтлуудыг шинжилбээс угсаатан нь хүмүүсийн биосоциал нийтлэг бөгөөд угсаатныг хооронд нь ялган салгах дараах шинж тэмдгүүдтэй байна. Үүнд:

1. **Этнонимтай** – Угсаатанд оногдсон нэр. Ингэхдээ этнонимыг политономоос (нийт улсын ба мужийн нэр), топонимоос (орон нутгийн нэр), лингвонимоос (хэлний нэр), конфессионимоос (шашины нэр) тус тус ялган салгах шаардлагатай. Зарим тохиолдолд эдгээр нь холбоотой буюу бие биентэйгээ таарч тохирдог. Тухайлбал, япон хүн гэсэн уг нь этноним, япон хэл гэдэг нь лингвоним, япон орон бол политоним, японы арлууд гэдэг нь топоним болно.
2. **Угсаатны соёлын онцлог** буюу хэл, шашин, ёс заншил, зан үйл, ардын урлаг ба аман зохиол, ёс суртахууны хэм хэмжээ г.м. илэрч буй угсаатны соёлын онцлогоороо “тэд – бид” гэсэн хоёр хэсэгт ялгарна.
3. **Антропо-сэтгэл зүйн шинжүүдээрээ**, өөрөөр хэлбэл хүний зан араншигийн сэтгэл зүйн хэвшил, хүний бие махбодын гадаад төрх зэргээрээ ялгарна. Тэр нь бие хүн, нийтлэг гаралтай болохоо ухамсартай буюу ухамсарлахгүйгээр адилтгахад хүргэдэг. Ингэх тохиолдолд энэ шинжүүд нь угсаатны хамаадлыг тодорхойлоход анхдагч, эхлэх суурь болдог.
4. **Нэгдсэн нуутаг дэвсгэртэй** бөгөөд орчин цагийн дэлхийн угсаатан (этногенезис) бүрэлдэн тогтоход цаг үедээ чухал үүрэг гүйцэтгэсэн. Гэхдээ өнөөдөр ард түмний бөөн шилжилтийн улмаас угсаатныг ялган салгах ач холбогдоо алдаж буй.

Эдгээр шинж тэмдгүүдийн янз бүрийн хослол, бие биентэйгээ харьцаж байгаагаас шалтгаалан угсаатан судлалд угсаатны түүхэн гурван хэв маягийг тогтоодог: аймаг, ястан, үндэстэн. Эдгээр хэв маягийн аль нэг нь түүхэн хөгжлийн аль нэгэн үе шатанд тохирч байгаа юм: аймаг – хүй нэгдлийн байгуулалд; ястан – боолын ба феодалын нийгэмд; үндэстэн – капиталист формацид. Өнөөдөр дэлхийд эдгээр нийгмийн харилцааны байгууллууд нэгэн зэрэг байгаа болохоор угсаатны хэв маягуудыг ажиглах бололцоотой.

Ийнхүү танилцуулсан угсаатан ба угсаажилтын үзэл баримтлалуудад оновчтой ба оновчгүй тайлбарын үндэслэлүүд байна. Тэдгээр хандлагуудыг хослуулснаар ямар нэгэн тодорхой төсөөлөлийг бүрдүүлж чадна.

### **Ном зүй**

- Мастюгина Т.М., Перепелкин Л.С. Этнология. Народы России: История и современное положение. Учебное пособие. – М., 1997.
- Садохин А.П., Грушевицкая Т.Г. Этнология. – М., 2000.
- “Историческая этнология”. – М., 1998.
- Дамдинсүрэн Ц., Лувсандэндэв А. Орос, Монгол толь. – УБ., 1982.
- Бромлей Ю.В. Этносоциальные процессы: теория, история, современность. М., 1987.
- Гумилев Л.Н. Древняя Русь и Великая степь. – М., 1989; Этногенез и биосфера земли. М., 1994.
- Цэрэнханд Г. Угсаатны онолын асуудлаар эрдэмтдийн үзэл баримтлалын тухай. – Угсаатан судлал. Tomus XШ Fasc. 1-22. – УБ., 2001.
- Широкогоров С.М. Исследование основных принципов изменения этнических и этнографических явлений. – Шанхай, 1923.
- Хавх Н. Нийгмийн гүн ухаан. – УБ., 1996.
- Гумилёв Л.Н. Этногенез и биосфера земли. – М., 1984.
- Чижевский. Физические факторы исторического процесса. -- Калуга, 1924.
- Бромлей Ю.В. Очерки теории этноса. – М., 1983.

**Хураангуй**

**I. Саруул**

**Тус өгүүлэлд монголчуудын бишрэл сүсэгт холбоотой нэгэн өдрийг онцлон авч, тэр нь амьдрал ахуйд хэрхэн нөлөөлж байсныг тайлбарласан.**